

## МОНГОЛЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДУУ ХӨГЖМИЙН СУРГАЛТЫН ТАЛААРХ ЗАРИМ СУДАЛГАА

*Н.Долгорсүрэн, магистр, МУБИС*

### Abstract

We often face with the question of determining the fate and future developments. The central point of the issue is children and their characters. The most important influence on the development and nature of this muse is music.

Always feel beautiful melody to create a melody, it will make children productive, strongly increased expression, in addition, that is, the value Decrease depression and connects children with the legacy of culture and music. Luis Birkensho-Fleming stressed that lessons Mathematics and Ecology, will teach children the method of life. And the music will give the children a happy life reasons.

Music education is significant in strengthening the basics of sustainable development of Mongolia in a way of giving students scientific and technological advance based sustainable development as well as environmental, ecological and health education in phases by pairing the tradition of Mongolian nations for protecting of nature earth and their manners and skills of living in harmony with nature environment with international practices and of acculturating them in proper utilization approaches.

### Түлхүүр үг

Хөгжим, боловсрол, хөгжмийн сургалт, хөтөлбөр, сурах бичиг

### Удиртгал

Монгол улсын боловсролын салбарт хийгдэж байгаа өөрчлөлт шинэчлэлтийн нэг хэсэг нь урлаг уран сайхан, хөгжмийн боловсролын асуудал юм. Хүүхдийг багаас нь монгол ёс, зан үйлд сургаж үндэснийхээ урлаг соёлыг мэддэг, дээдэлж хүндэлдэг дадал, төлөвшилд сургах нь юунаас чухал. Гадаад улс орны хөгжил, хөгжмийн урлагийн түүхэн үеийг хөгжмийн хичээлээр судалсан, мэддэг хэдий ч монголоо гэсэн монгол хүн болгоход багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхийн үүрэг оршиж байна. Лойс Биркеншо-Флеминг математик байгалийн шинжлэлийн хичээл хүүхдэд амьдрах аргыг зааж өгдөг бол хөгжим болон урлагийн хичээл амьдрах шалтгааныг зааж өгдөг гэж онцлон тэмдэглэсэн байдаг.

Өнөөдөр ЕБС-ийн хөгжмийн багш нар ихээр дутагдалтай байгаа, сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах, багш нарын мэргэжлийн ур чадвар, заах арга зүй дутагдалтай гэж бид ярьдаг хэдий ч тоймтой арга хэмжээ авч шийдэлд хүрэхгүй байсаар байна.

Харин 2015-2016 оны хичээлийн жилд МУБИС-ийн УБТС хөгжмийн багшийн анги нээн хичээллүүлсэн нь 25 жилийн дараа соёл, урлагийн түүхэн уламжлалаа сэргээсэн явдал төдийгүй 2 жилийн дотор өдрийн ангийн 90, хөрвөх сургалтын 11, магистр 13, нийт 120-иод оюутан суралцагчидтай амжилттай хичээллэж байна.

Монголын боловсролын салбарт хамгийн дутагдалтай байгаа хөгжмийн багшийн эрэлт

хэрэгцээг тооцоолж, ЕБС-ийн дуу хөгжмийн сургалтын үүсэл хөгжил, өнөөгийн сурах бичгийн агуулгыг, Өвөрмонголын дундад сургуулийн дуу хөгжмийн баримжаа, сурах бичгийн агуулгатай зарим талаар харьцуулан судалж, ололт, дутагдалтай асуудалд дүгнэлт хийхэд оршино. Монголын хөгжмийн боловсролын сургалтын хөтөлбөрийн үүсэл хөгжлийг он, нэршил, агуулгаар нь харуулах; хөгжмийн багшийн өнөөгийн байдлыг аймаг, хотуудаар тоймлон судалж, хэрэгцээг тодорхойлох; Монголын ЕБС-ийн хөгжмийн сурах бичгүүдийн агуулга дахь цогц чадамж бүхий бүтээлүүдийг тоон үзүүлэлтээр боловсруулан харьцуулсан дүгнэлт хийсэн болно.

### Арга зүй

Монголын хөгжмийн боловсролын үүсэл хөгжлийг он, нэршил, агуулгаар нь тоймлон нэгтгэн харуулж, 1-9-р ангийн сурах бичгийн агуулга дахь дуулах сонсох, хөгжимдөх, бүжиглэх, зохион бүтээх цогц чадамжуудаар заах бүтээлийн тоог монголын 1-9-р ангийн 9 сурах бичиг, Өвөрмонголын 1-10-р ангийн 19 сурах бичиг нийт 28 сурах бичиг тус бүрээр гаргаж, гүйцэтгэлийн мэдээллийг Excel программ ашиглан статистик дүн шинжилгээ хийж үр дүнг авч үзлээ.

### Хөгжмийн боловсролын агуулга

Хүн төрөлхтнийг хөгжимгүйгээр төсөөлөхийн аргагүй учраас хөгжмийн

гайхамшиг, ач тусыг бүх нийтийн хүртээл болгохын тулд ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт тусгагдан 1 дүгээр ангиас эхлэн 9-р анги хүртэл хөгжмийн хичээл ордог.

Хүүхдийн хөгжил төлөвшилд хөгжмийн боловсролын хичээл чухал ач холбогдолтой бөгөөд хөгжмөөр дамжуулан хүртэх, уран бүтээлийг ойлгох, хэрэглээ болгох, авьяасаа бүтээлчээр хөгжүүлэх цогц чадамж бүхий иргэн төлөвшүүлэхийг бидний амьдарч байгаа нийгэм, орчин, цаг үе аяндаа шаардаж байгаа юм (Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр, 2014, х.74). Хүн хөгжмийн боловсролтой болсноор ертөнц, нийгмийн тухай мэдлэг нь системчлэгдэж, амьдрал, ажил үйлс, гэр бүл, ахуйдаа ч дэг, соёлтой хандахыг эрмэлздэг.

Судлаач, доктор Н.Жанцанноров “Хөгжмийн боловсрол гэдэг олон нийтийн хэрэг бөгөөд ард олон боловсролтой, мэдлэгтэй байхыг хичээдгийн адил болж өгвөл хүн бүр хөгжмийн боловсролтой байхыг эрмэлзэх л хэрэгтэй. Хөгжмийн нарийн ширийнийг мэдэрдэг, тэр мэдрэмжээ ашиглаж чаддаг хүн бусдаас арай илүү сэтгэнэ ээ дээ. Тэр хүний тархи илүү ажиллаж байна л гэсэн үг...” гэж хэлсэн нь хөгжмийн боловсрол хүн бүрд зайлшгүй хэрэгтэй байдгийг илэрхийлжээ.

## Сургалтын хөтөлбөр

Аливаа сургалтын агуулга, нийгэм цаг үеийнхээ тусгал болж өөрчлөгдөн шинэчлэгдэж байдаг. Хөгжмийн сургалт нь он, онуудад ямар нэршилтэй, ямар агуулгаар шинэчлэгдэн өөрчлөгдөж байсныг тоймлон хүснэгт 1-д үзүүлбэл: (Пүрэвсүрэн, 2007, х.41)

### Хүснэгт 1

Хөгжмийн хичээлийн нэршил, агуулга

| Он                | Нэршил       | Агуулга                                                                                                       |
|-------------------|--------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1925-1960-аад онд | Дууны хичээл | Дуулах үйл ажиллагаа                                                                                          |
| 1970-1990 онд     | Дуу хөгжим   | Дуулахаас гадна хөгжмийн анхны мэдэгдэхүүнтэй болгох                                                          |
| 2002-2004 онд     | Хөгжим бүжиг | Суралцагчдын оюуны хөгжил, авьяас билэг, гоо зүйн хүмүүжилд нөлөөлөх                                          |
| 2004 оноос        | Хөгжим       | Сургалтын уламжлал, шинэчлэл дээр суурилсан дэлхийн сонгодог хөгжмийн сантай танилцуулах, ОУ-ын жишигт хүргэх |
| 2012 оноос        | Хөгжим       | Сурах арга барилд тулгуурласан, чадвараар дамжуулж агуулга эзэмшүүлэх, ОУ-ын жишигт хүргэх                    |

Дээрх агуулгыг анги бүрд хэдэн цагаар орж байсныг Хүснэгт 2-оор үзүүллээ. (Содномваанчиг, 2008, х.171) /хавсралт 1/

Хүснэгт 2.оос үзэхэд 1926 оноос хойш тухайн ангид орох агуулга, цаг өөрчлөгдөж байсан хэдий ч дуу хөгжмийн боловсролыг тасралтгүй олгосоор ирсэн нь харагдаж байна.

Өвөр монголын өөртөө засах оронд: Өвөр монголын өөртөө засах орон 1947 онд байгуулагдсан. Энэ үеэс хойш сургууль танхимын дуу хөгжмийн сургалтуудыг баримжаанд оруулан сургаж эхэлсэн. Түүнээс өмнө дуу, хөгжим, бүжгийн сургалт нь бүлгэм, гэрийн сургалтаар явагддаг байсан байна. 1941 онд Японд өндөр боловсрол эзэмшсэн Сөнөд хошууны засаг дарга Дэ Ван /Дэмчигноров/ гэгч хүн Охидын найрал дууны заан сургалтын сургууль байгуулж Өвөрмонгол эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурьт шинэ шинэчлэл хийсэн байдаг.

### Хүснэгт 3

Өвөрмонголын дуу хөгжмийн хичээлийн үүсэл хөгжил, нэршил, цаг

| Он              | Хэв шинж                                                                            | Нэршил                                                         | Цаг                     |
|-----------------|-------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------|-------------------------|
| 1950-аад оноос  | Бага сургууль                                                                       | Дууны хичээл                                                   | 2 цаг                   |
| 1978 оноос      | Бага, дунд анги                                                                     | Дууны хичээл                                                   | 1 цаг                   |
| 1982 оноос      | Бага, дунд анги<br>Өндөр анги                                                       | “Дуу хөгжим” хичээл<br>Сонирхомж хичээл                        | 1 цаг<br>1 цаг          |
| 2012-2013 оноос | Бага анги /1-5/<br>Дунд анги /6-9/<br>Өндөр анги /10-12/ зөвхөн 10-р ангидаа ордог. | “Дуу хөгжим” хичээл<br>“Дуу хөгжим” хичээл<br>Сонирхомж хичээл | 2 цаг<br>1 цаг<br>1 цаг |



сурган хүмүүжлийн хорооноос Дуу хөгжмийн хичээлийн баримжаа, сурах бичгүүдийг хэвлэн тараадаг.

## Судалгааны хэсэг

- Монголын ЕБС-ийн бага дунд ангийн сурах бичгийн агуулгыг Өвөр Монголын бага, дунд сургуулийн сурах бичигтэй харьцуулан судалж үзлээ. Үүнд: Монгол улсын 9, Өвөр монголын 18 бичигтэй ажилласан болно. Ингэхдээ Ардын дууг хэрхэн хичээлд оруулсныг давхар тоон үзүүлэлтээр гаргаж, судлан үзсэн юм. Тухайлбал: Өвөрмонголын сурах бичгүүд улирал бүр хэвлэгдэн гардаг. Тиймээс сурах бичиг тус бүрээр нь задлан шинжилж үзсэнээ тоймлон харуулбал:

### 2. Хүснэгт 4

Дуу хөгжим I Дээд дэвтэр


Дуу хөгжим I Доод дэвтэр

| Чадамж        | Бүтээлийн тоо | Сэдэв     | Тоо | Дүгнэлт             | Чадамж        | Бүтээлийн тоо | Сэдэв     | Тоо | Дүгнэлт      |
|---------------|---------------|-----------|-----|---------------------|---------------|---------------|-----------|-----|--------------|
| Дуулах        | 11            | Ардын дуу | 1   | Ардын дуу -4 байна. | Дуулах        | 12            | Ардын дуу | 2   | Дуу- 2 байна |
| Хөгжимдөх     | 2             |           | 2   |                     | Хөгжимдөх     | 1             |           |     |              |
| Бүжиглэх      |               |           |     |                     | Бүжиглэх      | 1             |           |     |              |
| Сонсох        | 6             |           | 1   |                     | Сонсох        | 7             |           |     |              |
| Зохион бүтээх | 5             |           |     |                     | Зохион бүтээх | 1             |           |     |              |

Дүгнэлт: “Дуу хөгжим-I” дээд, доод дэвтэр дэх агуулгыг дуулах, сонсох, хөгжимдөх, бүжиглэх, зохион бүтээх 5 үйлээр тоон үзүүлэлтээр гаргаж харьцуулан тус бүрд нь дүгнэлт хийж ажилласан болно. Жишээ болгож дуулах, сонсох үйлийн судалгааг авлаа.

### График 2

Дуулах үйл ажиллагаагаар сурах дууны тоон харьцуулалт




Дуулах-Өвөрмонголын ЕБС-ийн сургалтын баримжаа /хөтөлбөр/, дуу хөгжмийн сурах бичигт 1-9-р ангидаа нийт 201 дууг сурахаар оруулсан нь хүүхдийг бага наснаас нь дууны хөг аялгуугаар хөгжүүлэх илүү үр дүнтэй байдгийг нь харуулж байна. 11 наснаас /өсвөр нас/ хүүхдийн хоолойн өөрчлөлт явагдах арай цөөн дуу заахаар байгаа нь тохиромжтой байна. Сонсох 1-9-р ангидаа нийт 205 бүтээл сонсож, танин мэдэх, ялгах, дүрслэн илэрхийлэхээр оруулсан ба өсвөр насны /шилжилтийн/ 6-9-р ангид нь 128 буюу 63% байгаа нь энэ насны хүүхдийн хөгжлийн онцлогт тохиромжтой бөгөөд анги хамт олноороо, бүлгээр, хамтаар хөгжихөд нөлөөтэй гэж үзэж байна.

- Ардын дуугаа IV-VI ангидаа 16 дуу сурах нь бага тоо харагдаж байгаа хэдий ч I-III ангидаа 40, VII-IX ангидаа 38 дуу сурч байгаа нь ардын арвин их өв сангаасаа тасралтгүй суралцаж байгаа нь харагдаж байна.

### Зураг 3

Суралцагчдын сурах дууны агуулга дахь ардын дууны тоо



3. 2015 онд Оюунбилэг Ч, ба бус., (2015) зохиосон одоо судалж байгаа “Хөгжим” 1-9-р ангийн сурах бичигт анализ хийж харьцуулан үзээд жишээг хүснэгт 1-ээр зөвхөн 1-р ангийн жишээгээр авлаа.

Хүснэгт 5

А.Бага анги: Хөгжим I анги

|        | Сэдэв            | Тоо | Дүгнэлт                                                                 |
|--------|------------------|-----|-------------------------------------------------------------------------|
|        | Эх орон          | 4   |                                                                         |
| Дуулах | Танин мэдэхүй    | 4   | Хөгжим I ангийн номонд нийтдээ:<br>Дууль-14<br>Сонсьё-10<br>Ардын дуу 0 |
|        | Аав, ээж         | 3   |                                                                         |
|        | Сургууль         | 3   |                                                                         |
|        | Эх орон          | 7   |                                                                         |
| Сонсох | Аав, ээж         | 1   |                                                                         |
|        | Техник технологи | 2   |                                                                         |
|        |                  |     |                                                                         |

Зураг 4

1-5-р ангид сурах дууны тоо



Дүгнэлт: Монголын бага боловсролын “Хөгжим” 1-5-р ангийн сурах бичигт /2015/ нийтдээ 99 дуу заагдахаар орсон байна. Гэтэл хүүхдийн нас биеийн онцлог, хоолойн багтаамжид тохирсон Буриад ардын дуу Ёохор, Баруун монгол ардын дуу “Хотгойдын унага” гэх мэт ардын дуунуудыг Өвөрмонголын сургалтын хөтөлбөр,

сурах бичгүүдийн агуулгатай ойролцоо тоотойгоор зааж сургахаар оруулах нь зүйтэй байна.

Сонсох: “Хөгжим” 1-5-р ангийн сурах бичигт /2015/ нийтдээ 65 дуу хөгжмийн бүтээл сонсож илэрхийлэх нь. Энэ нь хүүхэд багаасаа хөгжмийн бүтээл сонсох чадвартайгаар хөгжин төлөвшихөд ач холбогдолтой.


Хүснэгт 6

Б. Дунд анги: Хөгжим 6-9-р анги /Жишээ хүснэгтийг 6-р ангиар авлаа/

| Чадамж | Тоо | Сэдэв     | Тоо | Дүгнэлт     |
|--------|-----|-----------|-----|-------------|
| Дуулах | 11  | Ардын дуу | 1   | Ардын дуу-3 |
| Сонсох | 4   |           | 2   |             |

Зураг 5


6-9-р ангид сурах дууны тоон харьцуулалт



6-9 ангиудад заагдах дуу нь 33, сонсох бүтээл нь 46 байгаа нь Өвөрмонголын 6-9-р ангийн сурах бичгийн агуулга, нас сэтгэхүйн онцлогт тохируулан бүтээлээ сонгосон зэрэг нь ойролцоо байна. Тухайн ангиудын сурах бичиг дэх ардын дууг зураг 6-д үзүүлээ.

## Зураг 6

6-9-р ангид сурах дууны агуулга дахь ардын дууны тоо



Цөм хөтөлбөрт 6-9-р ангид гадаад, дотоодын сонгодог урлаг талаасаа судлах агуулгатай байгаа болохоор эдгээр сурах бичигт ардын дуу цөөн оржээ.

## Дүгнэлт

Аймаг, хотуудад нийт 164 хөгжмийн багш дутагдалтай байна. Энэ нь СУИС, МУБИС-ийн хөгжмийн багшийн ангийн оюутнуудын элсэлт, төгсөлтийн тоог тандан үзвэл 2019-2020 оны төгсөлтөөс хойш хангагдах боломж харагдаж байгаа хэдий ч мэргэжлийн бус 302 хөгжмийн багш байгаа нь өнөөгийн боловсролын чанарын шинэчлэл, хүүхэд нэг бүрийн авьяасыг хөгжүүлэхэд арга зүйн хувьд дутагдалтай учраас хөрвүүлэн бэлтгэх тусгай нэмэлт хөтөлбөр боловсруулан ажиллах хэрэгцээ байна.

- Баян-Өлгий-11, Төв-11, нийслэлийн 8 дүүрэгт 52 хөгжмийн багш дутагдалтай байгаад дүгнэлт хийж тухайн аймаг, хотын боловсрол соёлын газруудтай холбогдон бодлогоор хамтран ажиллах санааг дэвшүүлж байна.
- Өвөрмонголын ЕБС-ийн дуу хөгжмийн сурах бичигт 1-9-р ангидаа нийт 201, монголын сурах бичигт 132 дууг сурахаар оруулсныг харахад Өвөрмонголын дуу хөгжмийн сургалт хүүхдийг бага наснаас нь дууны хөг аялгуугаар хөгжүүлэхэд хүүхдийн хоолойн өнгө тогтож, үг хэллэг сайжирч, шүлгийн болон аялгууны шинж төрхийг илэрхийлэн бүтээлч чадвар хөгжиж илүү үр дүнтэй байдгийг нь харуулж байна.
- Сонсох бүтээлээр Өвөрмонголын ЕБС-ийн дуу хөгжмийн сурах бичигт 1-9-р ангидаа нийт 205, монгол 111 бүтээл сонсож, танин мэдэх, ялгах, дүрслэн илэрхийлэхээр оруулсан нь агуулгын хувьд Өвөрмонголынх давуутайгаар хүүхдийн хөгжлийн онцлогт тохиромжтой, анги хамт олноороо, бүлгээр, хамтаар хөгжихөд нөлөөтэйг үзүүлсэн байна.
- Монголын боловсролын салбарт 91 жилийн түүхтэй хөгжмийн сургалтын түүхэн уламжлал, шинэчлэлийн онцлогийг харгалзан өнөөдрийн хэт онолжсон хөтөлбөр, сурах бичгүүдэд шүүмжлэлтэй хандан хамтран ажиллах шаардлагатай байна.
- Суурь боловсролын цөм хөтөлбөрийн 11.2.4-т “Үндэсний болон хүн төрөлхтний урлагийн

баялаг өв сан, үнэт зүйлсийг хүндэтгэн бахархаж, хамгаалдаг болно...” гэсэнчлэн ӨМӨЗО-ны дуу хөгжмийн баримжаа, сурах бичгийн агуулгаас санаа авч үндэсний өв соёл, дуу хуураа Монголын ЕБС-ийн сурах бичигтээ түлхүү тусгах хэрэгтэй байгааг онцлон үүнд холбогдох байгууллага, хүмүүс хамтран ажиллах хэрэгтэй байна гэж дүгнэлээ.

## Ашигласан материал

- Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар: Колорфул.
- БСШУЯ. (2015). ЕБСургуулийн суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. Улаанбаатар
- Дон, Кампбелл. (2012). Хүүхдэд хөгжим сонсгож хөгжүүлэн хүмүүжүүлэх нь. Улаанбаатар
- Долгорсүрэн, Н., Баасанцэрэн, Х. (2013). Хөгжмийн багш бэлтгэх ажлын уламжлал, шинэчлэл, хөгжлийн тулгамдсан асуудал. Лавай. №11. Улаанбаатар
- Долгорсүрэн, Н. (2015). Хөгжмийн багш бэлтгэх ажлын уламжлал, шинэчлэл, цаашдын чиг хандлага. Лавай. №13. Улаанбаатар
- Оюунбилэг, Ч., Энхжаргал, В., Энхжаргал, Х. (2015). Хөгжим I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX сурах бичиг. Улаанбаатар: Ном хур
- Өвөрмонголын Сурган хүмүүжлийн хичээлийн баримжаа. (2012). Дуу хөгжим I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX, X сурах бичиг. Хөх хот: Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
- Пүрэвсүрэн, Д. (2007). Монголын хөгжмийн боловсролын уламжлал, шинэчлэл. Улаанбаатар: Сод пресс
- Содномваанчиг, Г. (2008). Монголын бага, дунд боловсролын сургалтын агуулгын хөгжлийн түүхэн тойм. Улаанбаатар: Сод пресс
- Эрдэнэчимэг, Л., Долгорсүрэн, Н. (2012). Хөгжим VII сурах бичиг. Улаанбаатар: Адмон принт

## Хавсралт1

## Хүснэгт 2: Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн сургалтын төлөвлөгөөний харьцуулалт

| №  | Сургалтын төлөвлөгөөний цаг                                                                                  | I  | II | III | IV | V  | VI | VII | VIII | IX | цаг |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------|----|----|-----|----|----|----|-----|------|----|-----|
| 1  | 1926 оны бага сургуулийн программ /1925 оны багш нарын II хурал/                                             | 1  | 1  | 1   | 1  |    |    |     |      |    | 120 |
| 2  | 1933 дунд ангийн сургалтын төлөвлөгөө /БНМАУ-ын СНЗ-өөс батлан гарсан сургалтын нэгдсэн төлөвлөгөө/          |    |    |     |    | 2  | 2  | 2   |      |    | 180 |
| 3  | 1940 -54 онуудад ороогүй                                                                                     |    |    |     |    |    |    |     |      |    |     |
| 4  | 1955 оны бага, 7 ба 10 жилийн дунд сургуулиудын төлөвлөгөө                                                   | 1  | 1  | 1   | 1  |    |    |     |      |    | 120 |
| 5  | 1963 оны ЕБС-ийн сургалтын төлөвлөгөө /МАХН-ын 13-р их хурал/                                                | 1  | 1  | 1   | 1  | 1  | 1  | 1   |      |    |     |
| 6  | 1963-1971 он /С.Жадамбаагийн боловсруулсан дууны хичээлийн сургалтын төлөвлөгөө/                             | 1  | 1  | 1   | 1  | 1  | 1  | 1   |      |    | 241 |
| 7  | ЕБС-н 10 жилийн хөгжмийн боловсролын сургалтын төлөвлөгөө 1972-1987он                                        | 1  | 1  | 1   | 1  | 1  | 1  | 1   | 1    |    | 274 |
| 8  | 1987-1994                                                                                                    | 1  | 1  | 1   | 1  | 1  | 1  | 1   |      |    | 241 |
| 9  | 1994-1998                                                                                                    | 2  | 2  | 2   | 2  | 2  |    |     |      |    | 330 |
| 10 | 1998-2002 стандартын цөм хөтөлбөрт                                                                           | 52 | 68 | 52  | 68 | 61 |    |     |      |    | 301 |
| 11 | 2002-2004онд                                                                                                 | 1  | 1  | 1   | 1  | 1  | 1  | 1   | 1    | 1  | 328 |
| 12 | ЕБС-н 11 жилийн хөгжмийн боловсролын сургалтын төлөвлөгөө 2005-2007 оноос /урлаг, гоо зүй/                   | 1  | 1  | 1   | 1  | 1  | 1  | 1   | 1    | 1  | 328 |
| 13 | ЕБС-н 11 жилийн хөгжмийн боловсролын сургалтын төлөвлөгөө 2007-2008оноос                                     | 1  | 1  | 1   | 1  | 1  | 1  | 1   | 1    | 1  | 310 |
| 14 | Бага, дунд боловсролын шинэчлэлийн хүрээнд хийгдэх ЕБС-н хөгжмийн боловсролын сургалтын төлөвлөгөө 2012оноос | 2  | 2  | 2   | 1  | 1  | 1  | 1   | 1    | 1  | 480 |

## Хавсралт 2

## Хүснэгт 4. Хөгжмийн багшийн эрэлт хэрэгцээ

| Аймаг       | Сургуулийн тоо | Хэв шинж |       | Хөгжмийн хичээлийн цаг               | Хэрэгцээгэй хөгжмийн багш | Одоо ажиллаж байгаа хөгжмийн багш | Мэргэжлийн бус | Зөрүү |
|-------------|----------------|----------|-------|--------------------------------------|---------------------------|-----------------------------------|----------------|-------|
|             |                | Бага     | Дунд  |                                      |                           |                                   |                |       |
| Архангай    | 33             | 325      | 212   | 434+108+212=754ц:<br>19норм, 40 багш | 40                        | 31                                | 15             | 9     |
| Баян-Өлгий  | 43             | 463      | 268   | 616+155+268=1'039                    | 54                        | 47                                | 20             | 11    |
| Баянхонгор  | 29             | 307      | 195   | 408+102+195=706                      | 37                        | 31                                | 17             | 6     |
| Булган      | 22             | 206      | 122   | 273+69+122=466                       | 25                        | 20                                | 10             | 5     |
| Говь-Алтай  | 28             | 241      | 158   | 320+80+158=558                       | 29                        | 25                                | 12             | 4     |
| Дорноговь   | 21             | 222      | 140   | 296+74+140=510                       | 27                        | 24                                | 12             | 3     |
| Дорнод      | 26             | 264      | 175   | 352+88+175=615                       | 32                        | 27                                | 13             | 5     |
| Дундговь    | 19             | 166      | 118   | 221+55+118=394                       | 21                        | 24                                | 12             | 3     |
| Завхан      | 30             | 281      | 191   | 374+94+191=660                       | 35                        | 32                                | 15             | 3     |
| Өвөрхангай  | 30             | 383      | 251   | 510+127+251=889                      | 47                        | 38                                | 18             | 9     |
| Өмнөговь    | 20             | 198      | 147   | 320+80+147=547                       | 29                        | 29                                | 6              |       |
| Сүхбаатар   | 16             | 190      | 131   | 253+63+131=447                       | 23                        | 22                                | 11             | 1     |
| Сэлэнгэ     | 34             | 348      | 228   | 464+116+228=808                      | 42                        | 35                                | 16             | 7     |
| Төв         | 31             | 301      | 194   | 401+100+194=695                      | 36                        | 25                                | 12             | 11    |
| Увс         | 30             | 358      | 217   | 477+119+217=813                      | 43                        | 34                                | 14             | 9     |
| Ховд        | 25             | 319      | 212   | 425+106+212=743                      | 39                        | 32                                | 13             | 7     |
| Хөвсгөл     | 36             | 463      | 297   | 617+154+297=1.068                    | 56                        | 51                                | 18             | 5     |
| Хэнтий      | 26             | 278      | 192   | 370+92+192=654                       | 34                        | 28                                | 15             | 6     |
| Дархан-Уул  | 26             | 315      | 215   | 420+105+215=740                      | 39                        | 35                                | 16             | 4     |
| Улаанбаатар | 255            | 3.782    | 2.269 | 5.042+1.260+2.269=8.571              | 451                       | 399                               | 24             | 52    |
| Орхон       | 22             | 312      | 208   | 516+130+208=854                      | 44                        | 41                                | 13             | 3     |
| Говьсүмбэр  | 5              | 60       | 40    | 80+20+40=140                         | 7                         | 6                                 |                | 1     |
| Бусад       | 1              | 5        | 4     |                                      |                           |                                   |                |       |
| Дүн         | 808            | 9787     | 6184  | 22669                                | 1190                      | 1036                              | 302            | 164   |